



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баян-Овоо сумын Цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2020/27/СТА-ТШЗ

Цахим хуудас: Bayankhongor@audit.gov.mn

Баянхонгор хот
2020 он

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга
бөгөөд тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер: А.Цээням

Утас: 70442424 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn

Аудитор: Д.Энхтуяа

Утас: 99449299 Цахим хаяг: tomoo_etuya@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



Аудитын гэрчилгээ	3
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	7
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	7
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.13. Шилэн дансны мэдээлэл.....	8
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	8
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	9
3. Менежментийн захидал.....	10,
4.1. Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	12
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	13
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	14
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	16
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	17



Аудитын гэрчилгээ



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail: bayankhongor@audit.gov.mn

Г БАЯН-ОВОО СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Э.ЦЭНДБАЗАР ТАНАА

2020.02.27 № 1/247

тантай _____ -ны № _____ -г

Г Аудитын гэрчилгээ Г

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баян-Овоо сумын Цэцэрлэгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Баян-Овоо сумын Цэцэрлэгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитындээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баян-Овоо сумын Цэцэрлэгийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Д:Үбичиг хэрэг 2020-Албан тоот А4\

005020238




Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

Д:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\



Аудитын тайлан

2.1. Оршил

Баян-Овоо сумын Цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Цэцэрлэгийн эрхлэгч Э.Цэндбазар танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасаншийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу

Баян-Овоо сумын Цэцэрлэгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баян-Овоо сумын Цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 22-ноос 2020 оны 02 дугаар сарын 26-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 23-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймгийн "Глобал капитал аудит" ХХК-ийн аудитор Д.Энхтуяа хариуцаж хэрэгжүүлэв.

Баян-Овоо сумын Цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа 2019 оны 12 дугаар сарын 12-ний өдрийн .42 тоот дугаар бүхий албан бичгээр 2020 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Баян-Овоо сумын Цэцэрлэг нь тайлант хугацаанд Сургуулийн өмнөх боловсрол олгох эрхэм зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

- Хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлж, тогтолцооны шинэчлэл хийх
- Боловсролын чанар, хүртээмж, өрсөлдөх чадварыг сайжруулах
- Боловсрол, соёл урлаг спортын менежмент, эдийн засаг, санхүү, хөрөнгө оруулалтын бодлогыг шинэчлэх
- Төсвийн удирдлага, хэрэгжилтийн чанарыг сайжруулах зорилтууд дэвшүүлэн ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Баян-Овоо сумын Цэцэрлэг нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг баримтгүй байна.

Баян-Овоо сумын Цэцэрлэг нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Санхүүгийн тооцоолох групп ХХК-ний Acolous программ хангамж ашигладаг байна.

Баян-Овоо сумын Цэцэрлэгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Баян-Овоо сумын Цэцэрлэгийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 28 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны Здугаар улирлын байдлаарх санхүүгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, эрсдэлийн төвшин “их” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2,0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 134773,8 мянган төгрөгөөс 2,0 хувиар тооцон 2695, 4мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын төвшин 3666,9 мянган төгрөгөөр тооцсон нь төлөвлөлтийн шатанд сонгосон суурийг жилийн эцсийн үр дүнгээр тооцоноос өөрчлөлт орсон болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Баян-Овоо сумын Цэцэрлэгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 6661,1 мянган төгрөгөөр буюу 8,7хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага		5	5
Дуусаагүй үйлдвэрлэл			
Бараа материал	3222.4	6216.7	2994.3
Үндсэн хөрөнгө	120933,2	118087,3	-2845,9
Үндсэн хөрөнгийн элэгдэл	-47093,6	-53908,1	-6814,5
Нийт хөрөнгө	77062,1	70401.0	-6661.1
Өр төлбөр	0	22.9	22.9
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	77062.1	70378,1	-6684.0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	77062.1	70401.0	-6661.1

Бараа материалын дансны үлдэгдэл 2994.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 29567,9 мянган төгрөгийн худалдан авалт хийж, бараа материалд орлого авч 26573,6 мянган төгрөгийн зарцуулалт гарснаас шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд өмнөх онуудад худалдаж авсан ашиглалтгүй нөөцөлсөн бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө тайлант онд төсвийн хөрөнгөөр 1220,8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч, сумын ИТХ-ын 2019.05.04-ны өдрийн 12 тоот тогтоолоор 4066,7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө акталж данснаас хассанаас шалтгаалжээ.

Үнэ төлбөргүй шилжүүлсэн хөрөнгө байхгүй, биет бус хөрөнгөнд өөрчлөлт ороогүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 6661,1 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга гараагүй.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч

нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар тайлант онд төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө байхгүй байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрт зориулантусгай зориулалтын шилжүүлгээс 158855,1 мянган, орон нутгийн төсвөөс 15341,5 мянган, нийт 217419,6 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулахаар төсөв батлагджээ. Гүйцэтгэлээр батлагдсан санхүүжилтийг бүрэн авч зарцуулан төсвийн хэмнэлтийн 1945,4 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав. .

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд төсөв батлагдаагүй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 172251,1 мянган төгрөг буюу 98,9 хувьтай байна.

Нэмэлт төсөв: Тайлант онд нэмэлт санхүүжилтийн орлого байхгүй байна

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 28 эрсдэл тодорхойлж , гүйцэтгэлийн шатанд нийт 28 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримт боловсруулж мөрдөөгүй тул зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

1. Засгийн газраас тогтоосон хүүхдийн хоолны зардлын нормативыг баримталж байгаа эсэхийг хянах

2.13. Шилэн дансны мэдээлэл

Баян-Овоо сумын Цэцэрлэг нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг байршуулах үүрэгтэй. .

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	6	2	3
2	Хагас жил	4	4	4	0	
3	Улирал бүр	1	4	2	2	
4	Сар бүр	3	36	26	10	
5	Тухай бүр	8	96	55	41	
	Нийт	27	151	93	55	3

Шилэн дансны тухай хуулийн 6.1т заасны дагуу 3.1.1, 3.1.2 т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ гэсэн заалтыг зөрчиж 55 мэдээ, мэдээлэл хугацаа хоцроосон байна. Энэ нь Хагас жилээр шилэн дансанд аудит орж шалгасны дараа 1-3 дугаар сарын мэдээнүүд зөрүүтэй мэдээлсэн тул засах шаардлагатай гэсний улмаас зассан, мөн Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн

бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг гэсэн мэдээллийг өссөн дүнгээр мэдээлэх байсныг сар сараар нь мэдээлсэн байснаа зассан. 3 мэдээний хугацаа болоогүй байгаа, 2019 оны санхүүгийн тайлангийн аудит дуусангуут хугацаанд нь мэдээгээ байршуулна.

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Баян-Овоо сумын Цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Баян-Овоо сумын Цэцэрлэгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтболон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 дахь заалт, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл

1.1. Илрүүлэлт:

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байгууллагын онцлог, үйл ажиллагааг тусгаж боловсруулсан жишиг бичиг баримт байхгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана, 20 дугаар зүйлийн 20.2.2.-т “аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

1.2. Эрсдэл:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох стандартын шаардлага хангаагүй байх

1.3. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж, баталж, мөрдөж ажиллах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 5 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4.1. Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

СТ-1А

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	3,222,424.00	6,221,704.54
33	АВЛАГА	00.00	5,000.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	5,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	3,222,424.00	6,216,704.54
351	Түүхий эд материал	1,475,253.00	4,050,253.00
35110	Тусгай зориулалттай материал	1,475,253.00	4,050,253.00
354	Хангамжийн материал	1,747,171.00	2,166,451.54
35410	Бичиг хэргийн материал	00.00	244,200.00
35420	Аж ахуйн материал	100,000.00	202,700.00
35440	Түлш, шатах тослох материал	175,000.00	180,000.00
35460	Хүнсний материал	1,472,171.00	1,539,551.54
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	73,839,690.96	64,179,268.31
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	73,839,690.96	64,179,268.31
392	Биет хөрөнгө	68,017,690.96	58,357,268.31
39201	Барилга, байгууламж, орон сууц	76,645,270.00	76,645,270.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-21,964,293.27	-27,877,161.15
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	16,646,120.00	14,346,950.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-11,243,128.58	-10,993,616.81
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	16,766,576.16	16,368,397.22
39208	Хуримтлагдсан элэгдэл	-9,977,877.89	-12,425,659.26
39214	Бусад үндсэн хөрөнгө	4,344,583.00	2,975,174.61
39215	Хуримтлагдсан элэгдэл	-3,612,677.01	-2,611,636.30
39217	Ном	708,700.00	1,929,550.00
393	Биет бус хөрөнгө	5,822,000.00	5,822,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	5,822,000.00	5,822,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	77,062,114.96	70,400,972.85
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	22,900.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	22,900.00
413	Өглөг	00.00	22,900.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	00.00	22,900.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	77,062,114.96	70,378,072.85
51	Засгийн газрын хувь оролцоо	77,062,114.96	70,378,072.85
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	66,174,342.23	66,174,342.23
51101	Өмч: - төрийн	66,174,342.23	66,174,342.23
512	Хуримтлагдсан үр дүн	-70,897,452.61	-77,581,494.72
51210	Өмнөх үеийн үр дүн	-70,897,452.61	-70,897,452.61
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-6,684,042.11
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	81,785,225.34	81,785,225.34
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	77,062,114.96	70,400,972.85

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

СТ-2А

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /Төгрөгөөр/
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	147,353,055.60	176,663,455.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,397,655.60	17,808,355.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	144,955,400.00	158,855,100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	144,955,400.00	158,855,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	627,214.60	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	627,214.60	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	15,341,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	15,341,700.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,770,441.00	2,466,655.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	1,770,441.00	2,466,655.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	157,583,808.98	182,715,676.58
21	УРСГАЛ ЗАРДАЛ	157,583,808.98	182,715,676.58
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	148,193,268.71	178,156,617.39
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	88,583,074.00	113,806,241.00
210101	Үндсэн цалин	88,583,074.00	63,069,127.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	50,737,114.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	10,744,464.83	14,591,982.47
210201	Тэтгэврийн даатгал	7,168,446.14	9,898,012.72
210202	Тэтгэмжийн даатгал	876,008.09	1,184,291.25
210203	ҮОМШӨ-ний даатгал	772,797.00	937,672.43
210204	Ажилгүйдлийн даатгал	175,202.42	227,826.58
210205	Эрүүл мэндийн даатгал	1,752,011.18	2,344,179.50
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,755,574.00	12,299,582.34
210301	Гэрэл, цахилгаан	1,367,574.00	1,194,582.34
210302	Түлш, халаалт	12,275,000.00	11,105,000.00
210303	Цэвэр, бохир ус	113,000.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,410,220.00	2,486,000.00
210401	Бичиг хэрэг	421,440.00	604,800.00
210402	Тээвэр, шатахуун	390,000.00	330,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	687,400.00	1,050,000.00
210404	Ном, хэвлэл	00.00	11,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	180,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,911,380.00	309,700.00
2105	Нормативт зардал	20,682,862.00	21,226,769.46

**Баян-Овоо сумын Цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	79,860.00	60,000.00
210502	Хоол, хүнс	20,603,002.00	21,110,269.46
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	56,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	00.00	3,032,250.00
210604	Урсгал засвар	00.00	3,032,250.00
2107	Томилолт, зочны зардал	39,100.00	39,000.00
210702	Дотоод албан томилолт	39,100.00	39,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	00.00	250,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	250,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,977,973.88	10,424,792.12
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	376,000.00	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	16,400.00	175,340.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	10,585,573.88	10,249,452.12
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,390,540.27	4,559,059.19
2132	Бусад урсгал шилжүүлэг	8,475,441.00	2,613,375.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	924,072.00	2,589,375.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	846,369.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	6,465,000.00	24,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	240,000.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	914,914.71	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	914,914.71	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	122,117.66
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	122,117.66
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	184.56	1,823,566.53
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	184.56	1,823,566.53
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-10,230,753.38	-6,052,221.58
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	200,116.73	631,820.53
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	00.00	631,820.53
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	200,116.73	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-200,116.73	-631,820.53
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-10,430,870.11	-6,684,042.11

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

СТ-2А

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	147,353,055.60	176,663,455.00

**Баян-Овоо сумын Цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	147,353,055.60	176,663,455.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	144,955,400.00	158,855,100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	144,955,400.00	158,855,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	627,214.60	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	627,214.60	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	15,341,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	15,341,700.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,770,441.00	2,466,655.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	1,770,441.00	2,466,655.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	147,353,055.60	176,663,455.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	147,353,055.60	176,663,455.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	137,862,015.33	172,251,115.81
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	88,545,611.40	112,694,799.24
210101	Үндсэн цалин	82,086,449.51	101,423,744.00
210102	Нэмэгдэл	2,540,846.89	6,481,556.00
210104	Урамшуулал	3,918,315.00	4,789,499.24
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	10,265,899.89	15,806,144.23
210201	Тэтгэврийн даатгал	6,939,899.89	11,770,344.23
210202	Тэтгэмжийн даатгал	855,500.00	941,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	684,400.00	1,022,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	171,100.00	188,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,615,000.00	1,883,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,930,574.00	12,219,582.34
210301	Гэрэл, цахилгаан	1,367,574.00	1,194,582.34
210302	Түлш, халаалт	12,450,000.00	11,000,000.00
210303	Цэвэр, бохир ус	113,000.00	25,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,755,900.00	2,286,200.00
210401	Бичиг хэрэг	120,600.00	332,500.00
210402	Тээвэр, шатахуун	390,000.00	440,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,061,020.00	1,096,000.00
210404	Ном, хэвлэл	12,600.00	14,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	180,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	171,680.00	222,900.00
2105	Нормативт зардал	21,285,280.00	21,361,250.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	79,860.00	14,700.00
210502	Хоол, хүнс	21,017,820.00	21,162,650.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	187,600.00	183,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	64,200.00	3,056,250.00
210604	Урсгал засвар	64,200.00	3,056,250.00
2107	Томилолт, зочны зардал	39,100.00	39,000.00
210702	Дотоод албан томилолт	39,100.00	39,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	294,900.00	315,900.00

**Баян-Өвөө сумын Цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	294,900.00	65,900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	250,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,680,550.04	4,471,990.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,304,830.04	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	375,720.00	4,471,990.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,491,040.27	4,412,339.19
2132	Бусад урсгал шилжүүлэг	8,575,941.00	2,466,655.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	1,770,441.00	2,466,655.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	6,465,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	340,500.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	914,914.71	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	914,914.71	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	122,117.66
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	122,117.66
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	184.56	1,823,566.53
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	184.56	1,823,566.53
8	НИЙТ ЦЭВЭР ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

СТ-4А

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	66,174,342.23	81,785,225.34	70,897,452.61	77,062,114.96
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	66,174,342.23	81,785,225.34	70,897,452.61	77,062,114.96
DO8	Тайлант оны үр дүн			-6,684,042.11	-6,684,042.11
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	66,174,342.23	81,785,225.34	77,581,494.72	70,378,072.85

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

НТ-2

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	118,680,600.00	118,586,751.50	174,196,600.00	172,251,115.81
21	УРСГАЛ ЗАРДАЛ	118,680,600.00	118,586,751.50	174,196,600.00	172,251,115.81
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	118,631,100.00	118,537,251.50	174,154,700.00	172,251,115.81
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	83,797,334.48	82,735,990.50	114,387,600.00	112,694,799.24
210101	Үндсэн цалин	68,523,940.48	64,999,320.27	100,929,600.00	101,423,744.00
210102	Нэмэгдэл	4,132,406.00	5,061,842.23	6,458,700.00	6,481,556.00
210104	Урамшуулал	2,793,214.00	4,507,070.00	6,999,300.00	4,789,499.24
210105	Гэрээт ажлын хөлс	8,347,774.00	8,167,758.00	00.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	8,745,594.00	7,990,599.00	15,723,000.00	15,806,144.23
210201	Тэтгэврийн даатгал	8,745,594.00	7,990,599.00	11,956,600.00	11,919,044.23
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	00.00	941,500.00	941,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	00.00	753,200.00	873,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	00.00	188,300.00	188,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	00.00	1,883,400.00	1,883,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7,100,300.00	7,580,415.00	12,341,700.00	12,219,582.34
210301	Гэрэл, цахилгаан	621,500.00	828,715.00	1,571,100.00	1,194,582.34
210302	Түлш, халаалт	6,174,800.00	6,446,300.00	10,570,600.00	11,000,000.00
210303	Цэвэр, бохир ус	304,000.00	305,400.00	200,000.00	25,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	592,439.52	620,100.00	2,295,100.00	2,286,200.00
210401	Бичиг хэрэг	45,839.52	50,200.00	37,700.00	332,500.00
210402	Тээвэр, шатахуун	450,400.00	462,900.00	440,000.00	440,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	32,200.00	24,000.00	1,337,500.00	1,096,000.00

Баян-Овоо сумын Цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210404	Ном, хэвлэл	20,200.00	23,900.00	20,900.00	14,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	00.00	180,000.00	180,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	43,800.00	59,100.00	279,000.00	222,900.00
2105	Нормативт зардал	17,499,632.00	18,609,197.00	21,487,100.00	21,361,250.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	15,800.00	8,800.00	19,500.00	14,700.00
210502	Хоол, хүнс	17,294,332.00	18,410,897.00	21,280,000.00	21,162,650.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	189,500.00	189,500.00	187,600.00	183,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	00.00	25,300.00	3,064,200.00	3,056,250.00
210604	Урсгал засвар	00.00	25,300.00	3,064,200.00	3,056,250.00
2107	Томилолт, зочны зардал	48,700.00	45,000.00	39,100.00	39,000.00
210702	Дотоод албан томилолт	48,700.00	45,000.00	39,100.00	39,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	132,700.00	132,700.00	344,900.00	315,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	132,700.00	132,700.00	94,900.00	65,900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	00.00	250,000.00	250,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	714400.00	797950.00	4472000.00	4471990.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	714,400.00	797,950.00	00.00	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	00.00	4,472,000.00	4,471,990.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	49500.00	49500.00	41900.00	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	49,500.00	49,500.00	41,900.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	49,500.00	49,500.00	41,900.00	00.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	00.00	00.00	174,196,600.00	172,251,115.81
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	00.00	00.00	158,855,100.00	157,031,533.47
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	00.00	00.00	158,855,100.00	157,031,533.47
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	00.00	00.00	15,341,500.00	15,219,582.34
132001	Орон нутгийн	00.00	00.00	15,341,500.00	15,219,582.34

Баян-Овоо сумын Цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	төсвөөс				
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	10	10	10	10
620001	Удирдах ажилтан	1	1	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	9	9	4	4
620003	Үйлчлэх ажилтан	00	00	5	5
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	10	10	10	10
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	5	5	5	5
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	5	5	5	5

АУДИТЫН ТАЙЛАНГ:

БЭЛТГЭСЭН: АУДИТОР

АНХАН ШАТАНД ХЯНАСАН: АУДИТЫН МЕНЕЖЕР

ХОЁРДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:
ДАРГА ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.ЭНХТУЯА

А.ЦЭЭНЯМ

Б.МӨНХБАТ

Огноо: 2020.02.25